



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**  
FINANCIAL REGULATORY COMMISSION  
OF MONGOLIA

**ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2026 он**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

НЭГ. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

1.1 Үнэлгээ хийх үндэслэл

1.2 Үнэлгээний зорилго

1.3 Үнэлгээний зорилт

ХОЁР. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

2.1 Үнэлгээ хийх шалтгаан

2.2 Үнэлгээ хийх хүрээ

2.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

2.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр

2.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох

2.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ДӨРӨВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

4.1 1 болон 3 дугаар зүйл. Хуулийн зорилт, хуулийн нэр томъёо

4.2 8 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрөл

4.3 15 дугаар зүйл. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувьцаа

4.4 26 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн төлбөр, хөлс, хураамж

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
Аргачлал	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал
УИХ	Улсын Их Хурал
ДБД	Даатгалын багц дүрэм
МДЗЗХ	Монголын даатгалын зах зээлийн холбоо

## УДИРТГАЛ

“Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

“Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

## НЭГ. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

### 1.1. Үнэлгээ хийх үндэслэл

Монгол Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-ын Тамгын газраас Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны зохицуулалтын орчны хуулиуд дээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, УИХ-ын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санд байршуулах чиглэл ирүүлсэн. Уг чиглэлийн хавсралтаар Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг үнэлүүлэхээр оноосон байна.

Энэхүү тайлан нь дээрх чиглэлийн хүрээнд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг дангаар нь сонгон, түүний хэрэгжилтийн бодит байдал, эерэг болон сөрөг үр дагавар, практикт үүсч буй хүндрэл, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох боломжит хувилбарыг тодорхойлох зорилготой.

### 1.2. Үнэлгээний зорилго

Үнэлгээний үндсэн зорилго нь тус хууль батлагдсанаас хойш даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх, тухайн зохицуулалт өнөөгийн зах зээлийн нөхцөлд нийцэж байгаа эсэх, даатгалын мэргэжлийн оролцогч, даатгагч, даатгуулагч, хохирогч болон зохицуулагч байгууллагад ямар бодит үр дагавар бий болгож байгааг тогтооход оршино.

### 1.3. Үнэлгээний зорилт

1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн зорилт, зохицуулалтын бүтэц, хэрэгжилтийн хамрах хүрээг тодорхойлох;
2. Тусгай зөвшөөрөл, эрх, хяналт, тайлагнал, аудит, зах зээлийн ёс зүй, албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх;
3. Даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчийн үйл ажиллагаанд тулгарч буй эрх зүйн болон практик хүндрэл, хийдлийг тодорхойлох;
4. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, ашиг сонирхлын зөрчил, цахим борлуулалт, мэдээллийн ил тод байдал, мэргэжлийн ур чадварын шаардлагатай холбоотой сайжруулах санал боловсруулах;
5. Хуулийг хэвээр үлдээх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, эсхүл зарим зохицуулалтыг хүчингүй болгох хувилбарын аль нь зохистойг үнэлэх.

## ХОЁР. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- Харьцуулах хэлбэрийг сонгох
- Шалгуур үзүүлэлтийг томьёолох
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

### 1.1 Үнэлгээ хийх шалтгаан

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль нь 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр батлагдаж, 2010, 2015, 2017, 2022, 2023, 2024 онуудад нийт 8 удаа нэмэлт өөрчлөлт орж байсан боловч өнөөдрийг хүртэл нэг ч удаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр зааагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.10-т “Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.3.1-д “Санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ.” гэж, УИХ-ын 2025 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.5.1.3-т “Даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.” гэж, 5.5.1.4-т “Давхар даатгалын хураамж хэлбэрээр гадагш гарч байгаа валютын урсгал буурна.” гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр Тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын 3.2.4-т “нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан” бол гэж зааснаар СЗХ-ны зүгээс дээрх аргачлалын 3.2.2-т “хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалд нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс

улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол” гэсний дагуу энэхүү нөхцөл байдал үүссэн тухай үндэслэл бүхий зарчмын тодорхой саналууд гаргасан байна.

Иймд дээрх шалтгаануудын үүднээс Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэн энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

## 1.2 Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна. Иймд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий заалтуудаар үнэлгээний хүрээг тогтоох шаардлагатай байна.

Иймд дээрх шалгуур үзүүлэлтийг үндэслэн Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн дараах зохицуулалтууд үнэлгээ хийх хүрээнд хамаарна гэсэн үг. Үүнд:

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Зохицуулалтын агуулга
1	1 болон 3 дугаар зүйл	Хуулийн зорилт, хуулийн нэр томъёо
2	8 дугаар зүйл	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрөл
3	15 дугаар зүйл	Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувьцаа
4	26 дугаар зүйл	Даатгалын мэргэжлийн оролцогчийн төлбөр, хөлс, хураамж

## 1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараахь 2 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

Аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.

Аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

#### **1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр**

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс 3.5.3.1. “байх ёстой болон одоо байгаа байдал”<sup>1</sup>, мөн 3.5.3.4. “тохиолдол судлах”<sup>2</sup> хэлбэрүүдийг сонголоо. Учир нь, одоо байгаа нөхцөл байдлыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлагатай харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохын тулд “байх ёстой болон одоо байгаа” харьцуулах хэлбэрийг хэрэглэхээр заасан байна. Бид үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтуудын хувьд “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтээр шалгахаар тогтоосон тул үүнтэй уялдуулан дээрх харьцуулах хэлбэрийг сонгов.

Мөн үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтууд бусад улс орнуудын хувьд хэрхэн хэрэгждэг талаар судлах үүднээс “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг сонгосон болно. Учир нь бусад улс орнуудын Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомжийг харьцуулан судлах нь тус хуулийг сайжруулахад зайлшгүй хийгдэх ёстой судалгаа гэж үзлээ.

#### **1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох**

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “Зорилгод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “Практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

#### **1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох**

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, хэсгийн зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор

---

<sup>1</sup> Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

<sup>2</sup> Хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэмж хэмжээ өөр, өөр орчин нөхцөл (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд холбогдох хууль тогтоомж, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

## ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж ашигласан болно.

Харьцуулсан судалгаа: Монгол Улсын олон улсын гэрээ, олон улсын туршлага, мэдээллийг харьцуулалт хийх зорилгоор цуглуулж ашигласан. Цуглуулж ашигласан мэдээллийг “Ашигласан эх сурвалж”-ийн мэдээллийн жагсаалтаар харууллаа.

## ДӨРӨВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиас сонгож авсан зохицуулалтуудад дараахь байдлаар үнэлгээ хийлээ.

### 4.1. 1 болон 3 дугаар зүйл. Хуулийн зорилт, хуулийн нэр томъёо

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

[Хэвлэх](#)

1.1. Энэ хуулийн зорилт нь даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж

[Хэвлэх](#)

2.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

[Хэвлэх](#)

3.1. Энэ хуульд хэрэглэсэн энэ хуулийн 3.2-т зааснаас бусад нэр томъёог Даатгалын тухай хуульд заасан утгаар ойлгоно.

3.2. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.2.1. "даатгалын мэргэжлийн оролцогч" гэж даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийг;

3.2.2. "даатгалын төлөөлөгч" гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг;

3.2.3. "даатгалын зуучлагч" гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээдийг;

3.2.4. "даатгалын хохирол үнэлэгч" гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий этгээдийг;

3.2.5. "Зохицуулах хороо" гэж Даатгалын тухай хуулийн 12.1-д заасан байгууллагыг;

3.2.6. "гадаадын мэргэжлийн оролцогч" гэж гадаад улсад үүсгэн байгуулагдаж, үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийг.

3.3. Даатгагчаас цалинжин ажиллаж буй ажилтан энэ хуулийн 3.2.2-т заасан даатгалын төлөөлөгчид хамаарахгүй.

3.4. Дараахь этгээдийг энэ хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч гэж тооцохгүй:

3.4.1. даатгагчийн буюу даатгалын төлөөлөгчийн ажилтан;

3.4.2. даатгалын төлөөлөгч.

### 4.1.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

#### Хуулийн хамрах хүрээ олон улсын жишигт нийцэхгүй байна:

Даатгалын олон улсын зарчимд мэргэжлийн оролцогч гэдэгт амьдралын, ердийн, давхар даатгалын компаниуд мөн даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч, актуарч, андеррайтер, аудитын компаниудыг хамааруулдаг. Гэтэл өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд эдгээрээс зөвхөн даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийг даатгалын мэргэжлийн оролцогчид хамааруулсан бөгөөд бусад мэргэжлийн оролцогчдын талаарх зохицуулалт, эрх, үүрэг энэхүү хуулиар тодорхойгүй байгаа нь даатгуулагч иргэд, олон нийтэд буруу ойлголтыг бий болгож байна.

Даатгалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, даатгуулагч иргэдтэй шууд харилцдаг даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэр дундаа даатгуулагчийн олгосон эрхийн хүрээнд түүний ашиг сонирхлын төлөө даатгалын гэрээний харилцаанд оролцож буй даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг боловсронгуй, мэргэшсэн түвшинд эрхлэх, энэхүү дундын зуучлагчдын зах зээлийг илүү ёс зүйтэй, ил тод, шударга

өрсөлдөөнтэй зах зээл болгон хөгжүүлэх хүрээнд “Insurance intermediaries Act” буюу “Даатгалын зуучлалын хууль”-ийг олон улсад батлан мөрдүүлдэг байна.

Даатгалын хохирол үнэлэгчийн зохицуулалт олон улсын жишигт нийцэхгүй байна:

Олон улсын практикт даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн, даатгалын зүйлээс хамааран даатгалын хохирлыг хөрөнгийн үнэлгээчин, эмч эмнэлгийн ажилтан болон гамшиг гал түймэр, нисэх онгоц, барилга зэрэг салбарын нарийн мэдлэгтэй мэргэшсэн этгээдүүд хохирлыг үнэлэх шаардлагатай байдаг боловч манай улсад ихэвчлэн хөрөнгийн үнэлгээ хийх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй даатгалын хохирол үнэлэгчид үйл ажиллагаа эрхэлж байна.

Мөн олон улсад даатгалын хохирол үнэлэгч этгээд нь ихэвчлэн даатгалын компанийн ажилтан, хувь хүн эсхүл хөндлөнгийн даатгалын хохирол үнэлэгч мэргэшсэн этгээд байж тухайн улсынхаа Даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг байна. Тухайлбал, БНСУ нь даатгалын хохирол үнэлэгч этгээдэд тусгай зөвшөөрөл олгодоггүй бөгөөд харин даатгалын мэргэшсэн хохирол үнэлэгчийн эрхийг олгодог. Улмаар даатгалын компани бүр мэргэшсэн хохирол үнэлэгчийг авч ажиллуулах эсвэл хохирол үнэлгээний мэргэшсэн компанитай хамтран ажиллах шаардлага тавьдаг бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн хохирол үнэлэгч нь зөвхөн хохирлыг үнэлээд зогсохгүй, хохирол учирсныг баталгаажуулах, тухайн хохирол нь даатгалын тохиолдлын улмаас учирсан эсэх дүгнэлт гаргах, хохирлыг үнэлж, нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох, даатгалын нөхөн төлбөрийн баримт бичгийг боловсруулж, даатгуулагчид өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрдөг байна. Харин Филиппин улсын хувьд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд хохирол үнэлэгчийг даатгагчид нөхөн төлбөрийн хэмжээг үнэлж өгөх бие даасан хохирол үнэлэгч (independent adjuster), даатгуулагчид нөхөн төлбөрийн хэмжээг үнэлж өгөх (public adjuster) гэж ангилж, зөвшөөрлийг олгодог байна.

Хуулийн нэр томъёо олон улсын жишигт нийцэхгүй байна:

Дараах нэр томъёонууд олон улсын жишигт нийцэхгүй байна. Үүнд:

- Олон улсад даатгалын зуучлагчийг “брокер” гэж нэрлэж хэвшсэн байдаг бөгөөд хуулийн төсөлд “даатгалын зуучлагч” гэж томъёолж байгаа нь олон улсын жишигт нийцэхгүй, гадны хөрөнгө оруулагчид болон гадаадын даатгалын компани, зуучлагчид ойлгомжгүй байдлыг бий болгож байна.
- Банкны тухай хуулийн 6.2.3-т “даатгалын зуучлагч”<sup>3</sup> гэж заасны дагуу банк нь СЗХ-оос даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг. Гэвч Даатгалын мэргэжлийн ороцогчийн тухай хуульд холбогдох зохицуулалт тусгагдаагүй, ойлгомжгүй байдал бий болгож байна.

---

<sup>3</sup> <https://legalinfo.mn/mn/detail/108>

- Хуульд “даатгалын мэргэжлийн оролцогч”-ийг томъёолсон нь дээр дурдсанчлан олон нийтэд буруу ойлголтыг хүргэж байна.
- Даатгалын хохирол үнэлэгчийн томъёолол нь дээр дурдсанчлан олон улсын жишигт нийцэхгүй байна.
- Аливаа цахим, дэвшилтэт технологи ашиглан даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулахтай холбоотой нэр томъёо болон зохицуулалт хуульд тусгагдаагүй байна.

#### 4.1.2 Практикт нийцэж байгаа байдал:

Тус хуулиар даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих талаар зохицуулсан байдаг бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын зуучлагч 42 компани, давхар даатгалын зуучлагч компани 12, үүнээс 9 банк даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 29 компани, даатгалын 1143 төлөөлөгч даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.<sup>4</sup> Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлтийн харьцааг 2021-2025 оны байдлаар авч үзвэл дунджаар нийт хураамжийн 25.2 хувийг даатгалын зуучлагч, 30.9 хувийг даатгалын төлөөлөгч тус тус төвлөрүүлсэн<sup>5</sup>. Тайлант хугацаанд 29 даатгалын хохирол үнэлэгч компани 87,3 тэрбум төгрөг бүхий 44,097 даатгалын хохирлыг үнэлж 6,1 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлоготой ажиллажээ<sup>6</sup>.

Даатгалын зуучлагч нь мэргэжлийн түвшинд даатгуулагчийн ашиг сонирхол нийцэхүйц гэрээ, хэлцлийг байгуулах, эрсдэлийг шилжүүлэх үйл ажиллагааг хөндлөнгөөс зохион байгуулж байгаа этгээд болох тул даатгуулагчийн эрсдэл, ашиг сонирхлыг сайтар судалж, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нь нийцсэн үйл ажиллагаа явуулах ёстой. Даатгалын зуучлагч нь даатгуулагч, харилцагчид тохирох даатгалын бүтээгдэхүүнийг санал болгох үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд даатгагчдын талаар мэдээллээр хангах, эрэлт хэрэгцээ шаардлагыг нь нарийвчлан тодруулсны үндсэн дээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, хэлцэлд зуучлах зэргээр мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлэх нийтлэг үүрэгтэй байх, түүнчлэн үйлчилгээний доод стандартыг тодорхой болгох, хэрэгжүүлэх хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоог хангах боломжтой байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2021-2025 оны хооронд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийн олгосон, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн байдал дараах байдалтай байна. Үүнд:

<sup>4</sup> Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас [Даатгалын-салбарын-нэгтгэл-2025-он.pdf](#) холбоосоор харна уу.

<sup>5</sup> Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан, 2021-2025 оны тайлангуудаас түүвэрлэж, боловсруулав.

<sup>6</sup> Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас, [Даатгалын-салбарын-нэгтгэл-2025-он.pdf](#) холбоосоор харна уу.

Тусгай зөвшөөрөл	2021 он			2022 он			2023 он			2024 он			2025 он			Нийт		
	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн
Даатгалын зуучлагч	2	1		6	1		1	1	1	1	4	5	4	1	2	14	8	8

Мөн даатгалын зуучлагчийн тоо, бүрдүүлсэн хураамжийн орлого, зуучлалын шимтгэлийн орлогын хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Даатгалын зуучлагчийн тоо	57	63	63	60	63
Даатгалын зуучлагчийн зуучилсан даатгалын хураамжийн орлого	68,400.6	74,956.9	100,580.0	131,136.1	166,546.9
Даатгалын зуучлагчийн шимтгэлийн орлого	13,591.3	15,153.1	19,384.8	26,994.3	34,446.7
Дундаж шимтгэлийн хувь хэмжээ	19.9%	20.2%	19.3%	20.6%	20.7%

2025 оны байдлаар даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл бүхий 9 банк даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхэлж байна. Банк нь даатгалын компаниудтай байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн бүтээгдэхүүн үйлчилгээг өөрийн харилцагчдадаа түгээн борлуулж, борлуулалтын шимтгэлээс орлого олох, болзошгүй эрсдэлээс харилцагчид болон банканд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор даатгалын гэрээг зуучлан борлуулдаг этгээд бөгөөд олон улсад “банкашурэнс” гэж нэрлэн, нарийвчлан тусгайлан зохицуулсан байдаг. Энэ хүрээнд банкны даатгалын зуучлалын үйл ажиллагааг бусад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанаас ялган тодорхойлж, олон улсын жишгийн дагуу эрхлэх үйл ажиллагаанд нь тавигдах шаардлагыг тодорхой болгосноор иргэд, аж ахуйн нэгж, даатгуулагчдад зөв зүйтэй ойлголтыг өгөх юм.

Банк даатгалын зуучлагчийн тоо, бүрдүүлсэн хураамжийн орлого, зуучлалын шимтгэлийн орлогын хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Банк даатгалын зуучлагчийн тоо	10	10	10	9	9
Банк даатгалын зуучлагчийн зуучилсан хураамжийн орлого	26,612.3	29,835.5	43,337.3	55,915.4	76,022.1
Банк даатгалын зуучлагчийн шимтгэлийн орлого	6,195.8	6,889.9	9,949.4	12,756.5	17,498.0
Дундаж шимтгэлийн хувь хэмжээ	23.3%	23.1%	23.0%	22.8%	23.0%

Даатгалын бүтээгдэхүүний төрөл, түүнд хамаарах даатгалын зүйлээс шалтгаалан эмнэлгийн, гамшгийн, гал түймрийн, нисэх онгоцны, барилгын зэрэг эрсдэлийн хувьд даатгалын хохирлыг нарийн мэдлэгтэй мэргэшсэн этгээдүүд үнэлэх шаардлагатай байдаг боловч манай улсад ихэвчлэн авто тээврийн хэрэгсэл, хөрөнгийн хохирлыг үнэлэх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй даатгалын хохирол үнэлэгчид үйл ажиллагаа эрхэлж байна. Даатгалын хохирлын үнэлгээг хийж буй үнэлгээчид Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу Сангийн яамнаас хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулдаг хувь хүн байдаг бол Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг компанид олгодог.

2022-2025 оны хугацаанд даатгалын хохирол үнэлэгчийн тоо, хохирлын үнэлгээ, үнэлгээ хийсэн тохиолдлын тоо, хохирол үнэлгээний орлого дараах байдалтай байна. Үүнд:

	2022 он	2023 он	2024 он	2025 он
Даатгалын хохирол үнэлэгчийн тоо	25	24	29	29
Даатгалын хохирлын үнэлгээ	47,900.0	83,400.0	84,900.0	87,300.0
Үнэлгээ хийсэн тохиолдлын тоо	36,999	44,452	42,989	44,097
Хохирол үнэлгээний орлого	3,000.0	4,300.0	5,100.0	6,100.0
Дундаж үнэлгээний хувь хэмжээ	6.3%	5.2%	6.0%	7.0%

#### 4.2. 8 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрөл

##### 8 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрөл

8.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь дараахь төрөлтэй байна:

- 8.1.1. даатгалын төлөөлөгчийн;
- 8.1.2. даатгалын зуучлагчийн;
- 8.1.3. даатгалын хохирол үнэлэгчийн.

##### 4.2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Банк даатгалын зуучлагчид олгох зөвшөөрөл, зохицуулалт тодорхойгүй, олон улсын жишигт нийцэхгүй байна:

Дээр дурдсанчлан банк нь даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-оос авсны үндсэн дээр даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлдэг боловч холбогдох зуучлалын гол хууль болох Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулинд уг зохицуулалтыг тусгаагүй тул тусгай зөвшөөрөл хүсэгч, иргэд, олон нийтэд тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Олон улсад банк даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг “банкашурэнс” гэж нэрлэн, нарийвчлан тусгайлан зохицуулсан байдаг бөгөөд банкны даатгалын зуучлалын үйл ажиллагааг бусад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанаас ялган тодорхойлж, олон улсын жишгийн дагуу эрхлэх үйл ажиллагаанд нь тавигдах шаардлагыг тодорхой тусгадаг байна.

Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлага өндөр, төрд ачаалал үүсгэсэн зохицуулалт болж байна:

Хуулийн дагуу даатгалын төлөөлөгчийг даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг ойлгодог. Гэсэн хэдий ч даатгалын төлөөлөгч нь албан ёсоор даатгагчийг төлөөлөхийн тулд даатгагчаас олгосон зөвшөөрлөөс гадна СЗХ-оос тусгай зөвшөөрөл авахаар хуульд заасан нь даатгалын төлөөлөгч үйл ажиллагаагаа зохистой явуулахад илүү хүндрэлтэй бөгөөд үйл ажиллагааны цар хүрээтэй нь харьцуулахад хэт зохицуулалтын хамааралтай байна.

Ихэнхи улс орнуудад, тухайлбал Герман, Австрали, Япон, Бельги, Франц, Итали, Мексик, Нидерланд, Португал, Испани, Швейцарь, Их Британи, Сингапур, Солонгос, Кени улсуудын жишээгээр даатгалын төлөөлөгчийг зохицуулах байгууллагад бүртгүүлж, тавигдах шаардлагыг тусгаж, үйл ажиллагаандаа баримтлах хэм хэмжээг тодорхойлж өгсөн байдаг. Тухайлбал, даатгалын төлөөлөгч нь өөрийн төлөөлж байгаа даатгагчийг заавал дурдах буюу аль даатгагчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгааг даатгуулагчид мэдэгдэх, мөн даатгагчийн нэрийн өмнөөс гэрээ байгуулж байгаагийн хувьд гэрээ байгуулахтай холбогдон үүсэх хариуцлагыг зөвшөөрөл олгосон даатгагч дангаар хариуцахаар тодорхой зохицуулсан байдаг нь манай зохицуулалтаар бол тавигдах шаардлагуудыг хангасан тохиолдолд энгийн зөвшөөрөл олгодог зохицуулалттай ижил байдаг.

Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийн шаардлага өндөр, давхардсан төрд ачаалал үүсгэсэн зохицуулалт болж, даатгуулагч хохирлоо үнэлүүлэхэд зардал, цаг хугацаа их зарцуулж байна:

Дээр дурдсанчлан даатгалын хохирлын үнэлгээг хийж буй үнэлгээчид Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу Сангийн яамнаас хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулдаг хувь хүн байдаг бол Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг компанид олгож байгаа нь уялдаа холбоогүй, давхардсан зохицуулалт болж байна.

Олон улсад даатгалын хохирол үнэлэгч этгээд нь ихэвчлэн даатгалын компанийн ажилтан, хувь хүн эсхүл хөндлөнгийн хараат бус даатгалын хохирол үнэлэгч гэсэн мэргэшсэн этгээд байж тухайн улсынхаа Даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг байна. Даатгагчийн томилсон хохирол үнэлэгч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгагчийн нэрийн өмнөөс даатгалын хохирлын үнэлгээг гаргах бөгөөд даатгуулагч нь хөндлөнгийн хохирол үнэлэгчээр үнэлүүлэх хүсэлтийг даатгагчид гаргасан

бол, даатгагчийн томилсон хохирол үнэлэгчийн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй бол, мөн мэргэжлийн ур чадвар шаардлагатай, нарийн төвөгтэй байдлаар хийгдэх хохирол үнэлгээний хувьд хүсэлт гаргасан тохиолдолд хөндлөнгийн хохирол үнэлэгчид хандахаар зохицуулагддаг. Даатгагчийн томилох хохирол үнэлэгч нь хохирол үнэлэгчийн энгийн зөвшөөрөл авах шаардлагагүй, харин хөндлөнгийн хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд даатгалын хохирол үнэлэгчээр ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд хөндлөнгийн хохирол үнэлэгчийн энгийн зөвшөөрлийг олгодог байна.

#### 4.2.2 Практикт нийцэж байгаа байдал:

Практикт уг хуулиар банк даатгалын зуучлагчид тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт тодорхойгүй боловч 2025 оны байдлаар даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл бүхий 9 банк даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2021-2025 оны хооронд СЗХ-оос банк даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийн олгосон, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн байдал дараах байдалтай байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл	2021 он			2022 он			2023 он			2024 он			2025 он			Нийт		
	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн
Банк даатгалын зуучлагч		1								1	1				0	2	1	

Даатгагчийн албан ёсны зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын төлөөлөгчид СЗХ-оос тусгай зөвшөөрөл олгож байгаа нь зохицуулалтын хувьд шаардлагагүй буюу төрд ачаалал үүсгэсэн ач холбогдолгүй зохицуулалт болоод байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2021-2025 оны хооронд СЗХ-оос даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн олгосон, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн байдал дараах байдалтай байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл	2021 он			2022 он			2023 он			2024 он			2025 он			Нийт		
	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн
Даатгалын төлөөлөгч	85	159		157	71	189	83	44		102	7		185	1538	1539	612	1819	1728

Мөн 2022-2025 оны хугацаанд даатгалын төлөөлөгчийн тоо, бүрдүүлсэн хураамжийн орлого, төлөөлөгчийн шимтгэлийн орлогын хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

	/сая төгрөг/			
	2022 он	2023 он	2024 он	2025 он
Даатгалын төлөөлөгчийн тоо	2376	2416	2504	1143
Даатгалын төлөөлөгчийн бүрдүүлсэн хураамжийн орлого	61,200.0	136,400.0	190,300.0	201,600.0
Даатгалын төлөөлөгчийн шимтгэлийн орлого	17,800.0	21,400.0	28,200.0	33,500.0
Дундаж шимтгэлийн хувь хэмжээ	29.1%	15.7%	14.8%	16.6%

Даатгалын хохирлын үнэлгээг хийж буй үнэлгээчид Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу Сангийн яамнаас хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл, мөн дээрээс нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн дагуу даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг авч байгаа нь төрд ачаалал үүсгэсэн, давхардсан зохицуулалт болж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2021-2025 оны хооронд СЗХ-оос даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийн олгосон, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн байдал дараах байдалтай байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл	2021 он			2022 он			2023 он			2024 он			2025 он			Нийт		
	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн
Даатгалын хохирол үнэлэгч		1						1		5				1	2	5	3	2

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг СЗХ хэрэгжүүлэн ажилладаг

бөгөөд Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 “Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх” гэж заасны дагуу хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хянаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар СЗХ-нд ирүүлсэн нийт өргөдөл гомдлын 48.7 хувь буюу 475 өргөдөл, гомдол даатгалын үйл ажиллагаатай холбоотой бол үүний 7.0 хувь буюу 33 өргөдөл нь даатгалын хохирол үнэлгээтэй холбоотой ирүүлсэн гомдол эзэлж байна.<sup>7</sup>

#### 4.3. 15 дугаар зүйл. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувьцаа

15 дугаар зүйл. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувьцаа

15.1. Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн гаргаж буй бүх хувьцааны төлбөрийг мөнгөн хэлбэрээр хийнэ.

15.2. Даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчид Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл хамаарахгүй.

##### 4.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөхөд холбогдох зохицуулалт тодорхойгүй байна:

Хуульд даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт, тэдгээрт тавих хяналттай холбоотой зохицуулалт тусгагдаагүйн улмаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эцсийн өмчлөгчийг тогтооход хүндрэл үүсч, улмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөмтгий байдал нэмэгдэх аюул их байна.

##### 4.3.2 Практикт нийцэж байгаа байдал:

Хуульд дэрх зохицуулалт тусгагдаагүй ч СЗХ ДБД-ийн нэгдүгээр хавсралтаар баталсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт, тэдгээрт тавих хяналттай холбоотой зохицуулалтыг тусган ажилладаг.

2025 оны байдлаар даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувьцаа эзэмшигчийн тоо дараах байдалтай байна. Үүнд:

<sup>7</sup> Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны өргөдөл, гомдлын судалгааны тайлангаас, [2025-оны-өргөдөл,-гомдлын-судалгааны-тайлан.pdf](#) холбоосоор харна уу.

	Даатгалын зуучлагч	Даатгалын хохирол үнэлэгч
Хувьцаа эзэмшигчийн тоо	112	53

Мөн 2025 онд даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтийг СЗХ-оос шийдвэрлэсэн байдлыг доор үзүүлэв. Үүнд:

	Даатгалын зуучлагч	Даатгалын хохирол үнэлэгч
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлт	13	2

#### 4.4. 26 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн төлбөр, хөлс, хураамж

<b>26 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн төлбөр, хөлс, хураамж</b>		<a href="#">Хэвлэх</a>
26.1. Даатгалын мэргэжлийн оролцогч дор дурдсанаас бусад тохиолдолд даатгагчийн байгуулсан гэрээний дагуу төлөгдөж буй хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг хориглоно:		
26.1.1. даатгалын хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг даатгагч зөвшөөрсөн;		
26.1.2. Зохицуулах хорооноос эрх олгосон.		

##### 4.4.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгчид даатгалын орлогын шимтгэлийн хувь хэмжээгээ өрсөлдөж, зах зээлд сөрөг үр дагаварыг үүсгэж байна:

Даатгалын хураамжийн орлогын 20-40 хувийг даатгалын төлөөлөгч, зуучлагчийн шимтгэлийн зардал эзэлж байна. Гэтэл энэ хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь даатгалын компаниуд төлбөрийн чадвар, найдвартай байдал, туршлага, бүтээгдэхүүний хамгаалалт, онцлог шинж чанараар бус шимтгэлийн орлогын хэмжээгээр өрсөлдөх замаар бүтээгдэхүүнээ борлуулах сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Зарим улс орны туршлагыг харахад шаардлагатай тохиолдолд онцлох даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний хувьд даатгалын орлогын шимтгэлийн хувь хэмжээг хязгаарлах, даатгалын төлөөлөгч, зуучлагчийн бүртгэл, тайлагналыг боловсронгуй болгох, ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтуудыг хуулиндаа тусгаж, мэргэшсэн, шударга өрсөлдөөнт зах зээлийг бий болгодог байна.

Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгчийн эрх үүрэг тодорхойгүй, хариуцлагагүй байдал үүсээд байна:

Хуулинд даатгалын төлөөлөгч, зуучлагчийн үүрэг хариуцлагыг тодорхой тусгаагүйгээс<sup>8</sup> даатгагч, даатгуулагчийн хоорондын гэрээ ойлгомжгүй, хоёрдмол утгатай хийгдэх, ингэснээр даатгуулагчийн эрх ашиг зөрчигдөх зэрэг сөрөг үзэгдлүүд гарах эрсдэлийг бий болгож байна.

Түүнчлэн даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчийн үүрэг, хариуцлагын талаар нарийвчлан зохицуулаагүй тул мэргэжлийн оролцогчийн буруутай үйл ажиллагаанаас хохирсон харилцагчийн эрх ашгийг хэн хамгаалах нь тодорхойгүй байна.

#### **4.4.2 Практикт нийцэж байгаа байдал:**

СЗХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо мэдээг сүүлийн 5 жил буюу 2021-2025 оны байдлаар авч үзвэл нийт өргөдөл, гомдлын дунджаар 50 орчим хувь нь даатгалын салбарт хамааралтай байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 48.7 хувийг эзэлж байна. Даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх нь даатгалын нөхөн төлбөртэй холбоотой байсан бөгөөд дээрх өргөдөл, гомдлуудыг нарийвчлан харахад даатгалын компаниудын нөхөн төлбөр олгохоос татгалзсан тохиолдол 2021 онд 66.2, 2022 онд 61.0, 2023 онд 47.2, 2024 онд 61.2, 2025 онд 49.0 хувь байсан байна. Мөн өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрлийг авч үзвэл дийлэнхи нь жолоочийн хариуцлагын даатгал болон авто тээврийн хэрэгслийн даатгал эзэлж байна.<sup>9</sup> Өөрөөр хэлбэл, нөхөн төлбөр олгохоос татгалзсан тохиолдлын хувь өндөр байгаа нь нэг талаас даатгуулагчдын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ, холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл хангалтгүй, жолооч, даатгуулагч даатгалын гэрээний нөхцлүүдтэй бүрэн танилцаж, ойлгоогүй байгааг харуулж байна.

Дээр дурдсанчлан 2021-2025 он хүртэлх хугацаанд төвлөрүүлсэн даатгалын хураамжийн орлогын дүнд даатгалын зуучлагч болон төлөөлөгчийн оролцоо нь дунджаар 56.1 хувь байгаа бөгөөд энэ үзүүлэлтийг өргөдөл, гомдлын судалгааны үр дүнтэй уялдуулан авч үзвэл даатгалын зуучлагч, төлөөлөгч нь олон нийт, даатгуулагчдын даатгалын хэрэгцээгээ зөв үнэлэх, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тохируулан сонгох, даатгалын гэрээтэй бүрэн танилцаж, ойлгох зэрэгт чухал үүрэгтэй болох нь харагдаж байна.

Монгол Улсад даатгалын салбарын хөгжил хангалттай бус байгаа нь нэг талаас иргэдийн даатгалд итгэх итгэл, ойлголт хангалтгүй, нөгөө талаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд суурилсан даатгалын бүтээгдэхүүнийг даатгагчид болон даатгалын бүтээгдэхүүнийг зуучлан борлуулах дундын зуучлагч, төлөөлөгчид мэргэжлийн түвшинд тайлбарлаж ойлгуулах, мэдээлэл хангалттай өгч чадахгүй байгаатай холбон тайлбарлаж

<sup>8</sup> Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Даатгалын тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд даатгалын төлөөлөгчийн эрх, үүрэг болон даатгалын зуучлагчийн эрх, үүрэг байдаггүй.

<sup>9</sup> Санхүүгийн зохицуулах хороо, Өргөдөл гомдлын судалгаа, 2021-2025 оны тайлангуудаас түүвэрлэж, боловсруулав.

болохоор байна. Олон улсын жишгээр даатгалын салбар дах дундын зуучлагчид нь олон нийтэд даатгалын талаарх зөв ойлголтыг түгээх, талуудын эрх ашгийг тэнцвэржүүлэхэд чухал үүрэгтэй нөлөөтэй байдаг.

МДЗЗХ-ны захиалгаар 2025 онд Санхүү эдийн засгийн их сургуулийн ахисан түвшний сургуулийн дэргэдэх Санхүүгийн зах зээлийн судалгааны хүрээлэнгээс олон нийтийн даатгалын мэдлэгийн түвшин, хэрэгцээг тодорхойлох, даатгалын үйлчилгээ авч байсан иргэд, байгууллагын харилцагчийн сэтгэл ханамжийг судлах зорилгоор улсын хэмжээнд 282 дунд болон ахла ангийн сурагчид, 250 оюутан, 679 иргэд, даатгалын компаниар үйлчлүүлсэн 345 хүн, 294 байгууллагыг хамруулан, санамсаргүй түүврийн аргаар хийсэн “Даатгалын салбарын багц судалгаа”<sup>10</sup>-ны үр дүнгээс одоогийн нөхцөл байдлыг дүгнэвэл:

- Иргэдийн даатгалын талаарх мэдлэг, ойлголт сул;
- Даатгалын компаниудын үйлчилгээний чанар, ялангуяа нөхөн төлбөрийн шийдвэрлэх хурд удаан, итгэл сул;
- Сайн дурын даатгалын хамрагдалт бага, албан журмын даатгал давамгайл;
- Хэрэглэгчийн итгэл сул;
- Мэдээллийн хүртээмж муу, ихэнхдээ сошиал сувгаар дамжин ирж байгаа нь албан ёсны эх сурвалж дутмаг;
- Үнэнч хэрэглэгчийн суурь сул;
- Хэрэглэгчийн боловсролыг системтэй нэмэгдүүлэх шаардлагатай;
- Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хангалтгүй (нөхөн төлбөрийн хурд, ил тод байдал, цахимжилт);
- Даатгалын зах зээлд инновац дутмаг;
- Хяналт, зохицуулалтыг бэхжүүлж, компанийн үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг олон нийтэд ил тод болгох.

Түүнчлэн тус судалгааны үр дүнд Монголын даатгалын салбарт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон бөгөөд дараах байдалтай байна. Үүнд:

- Даатгалын мэдээлэл түгээх суваг албан ёсны бус (сошиал, танилын хүрээ давамгайл);
- Иргэдийн даатгалд хамрагдахгүй байгаа шалтгаан нь ойлголт, мэдээлэл дутмаг;

---

<sup>10</sup> “Даатгалын салбарын багц судалгаа”, Санхүү эдийн засгийн их сургуулийн ахисан түвшний сургуулийн дэргэдэх Санхүүгийн зах зээлийн судалгааны хүрээлэн, 2025 он

- Даатгалын үйлчилгээнд итгэл сул, нөхөн төлбөрийн шийдвэрлэлт удаан, хүндрэлтэй;
- Сэтгэл ханамжид үнэ болон шимтгэл, хураамж сөргөөр нөлөөлдөг;
- Байгууллагууд даатгалын компаниудтай урт хугацааны тогтвортой харилцаа сул.

Санхүү эдийн засгийн их сургуулийн ахисан түвшний сургуулийн дэргэдэх Санхүүгийн зах зээлийн судалгааны хүрээлэнгээс хийсэн судалгааны үр дүнгээс харахад олон нийт, иргэд, даатгуулагчдын даатгалын талаар ойлголт, мэдлэгийг сайжруулах, даатгалын хэрэгцээгээ зөв үнэлэх, даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгцээ шаардлагадаа тохируулан оновчтой сонгох, түүнчлэн тэдний даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд ийнхүү нэмэгдүүлэхэд даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үүрэг оролцоо маш чухал болох нь тодорхой харагдаж байна.

Даатгалын гэрээ байгуулахад даатгалын зуучлагч, төлөөлөгч нь даатгалын хураамжаас бусад хэлбэрээр аливаа мөнгөн шагнал урамшууллыг авах, даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөрөөс бусад хэлбэрээр гэрээ байгуулсны төлөө шан харамж авах зэргийг зөрчилд тооцох шаардлагатай байна.

Мөн төлөөлж эсвэл зуучилж байгуулсан даатгалын гэрээний хүрээнд үүссэн даатгалын тохиолдолд нөхөн төлбөр гаргуулахтай холбоотой аливаа зөвлөгөө өгөхийг хязгаарлах нь даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг тэнцвэржүүлэхэд чухал ач холбогдолтой.

## ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль 2004 онд батлагдсанаас хойш даатгалын зах зээл хөгжих эрх зүйн суурь нөхцөл боломжуудыг олгож, даатгалын мэргэжлийн оролцогчдыг үүсгэн байгуулагдаж, зах зээлд эзлэх байр сууриа тодорхойлж, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг даатгуулагчдад хүргэн ажиллах нөхцөл боломжийг бий болгосноор уг хууль нь тодорхой хэмжээгээр даатгалын зах зээлд ач холбогдол, үр нөлөөгөө үзүүлж, үүргээ гүйцэтгэсээр ирсэн. Гэсэн хэдий ч хууль мөрдөгдөж эхэлснээс хойш тодорхой зарчмын шинж чанартай өөрчлөлт ороогүй бөгөөд даатгуулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд дараах асуудлуудад анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1. Хуулийн нэрийг “Даатгалын зуучлалын тухай хууль” болгон өөрчилж, тусгайлсан даатгалын дундын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай.
2. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, даатгалын зуучлалын үйл ажиллагаа дахь сүүлийн үеийн шаардлагатай нэр томъёоллыг шинээр оруулах шаардлагатай.
3. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн эрх үүргийг тодорхой болгож хариуцлагажуулах шаардлагатай.
4. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын асуудлыг холбогдох хуульд шилжүүлэх, даатгалын хохирлыг үнэлэх этгээд нь даатгалын компанийн ажилтан байх боломжийг бүрдүүлэх, мөн даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг бууруулах, давхардсан зохицуулалтыг арилгах шаардлагатай.
5. Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг бууруулах, төрд ачаалал үүсгэсэн ач холбогдолгүй зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай.
6. Олон улсын жишгийн дагуу банк даатгалын зуучлалын үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгон хуульд тусгах шаардлагатай.
7. Даатгалын орлогын шимтгэлтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих зохицуулалтуудыг тусгах шаардлагатай.
8. Даатгалын зуучлалын үйл ажиллагаанд цахим болон аливаа дэвшилтэд техник, технологи, программ хангамж ашиглахтай холбоотой зохицуулалтуудыг тусгах шаардлагатай.

### Хууль, эрх зүйн акт

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, 2004 он  
Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он  
Даатгалын тухай хууль, 2004 он  
Зөрчлийн тухай хууль, 2017 он  
Зөвшөөрлийн тухай хууль, 2022 он  
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 он  
Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, 2014 он  
Банкны тухай хууль, 2010 он  
Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2010 он  
Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он  
Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал, 2016 он  
Алсын хараа-2050, 2020 он  
Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 он  
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2025 он  
Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, 2022 он

### Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг

“Даатгалын салбарын багц судалгаа”, Санхүү эдийн засгийн их сургуулийн ахисан түвшний сургуулийн дэргэдэх Санхүүгийн зах зээлийн судалгааны хүрээлэн, 2025 он  
Санхүүгийн зохицуулах хорооны Өргөдөл, гомдлын судалгааны тайлан, 2021-2025 он  
Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан, 2021-2025 он